

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 08 дугаар сарын мэдээлэл

2022.08.24.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит IX хуралдаан 2022.08.05 нд хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

а/. Амьжиргааг дэмжих зөвлөл байгуулах тухай

б/. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэл, зээлийн дээд доод хязгаарыг тогтоох тухай.

в/. Хадлангийн талбай, Уурын зуухны газрын асуудал

г/. Сумын БЦГХЗ-ны 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан сонсох

-ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний баг суманд ажиллаж үнэлгээ хийв.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

-Аймгийн ОНХС-ийн ажлын хэсэг суманд ажиллаж, зөвлөгөө зөвлөмж өгч, сургалт зохион байгуулсан.

-Сургалт сурталчилгааны хүрээнд сумын Ахмадын хороотой хамтран архидалтын эсрэг “УРИАЛГА”-ыг цахим болон цаасаар гаргаж нийтэд сурталчлах арга хэмжээг авч байна.

- Эхийн сүүгээр хооллолтын дэлхийн 7 хоногийг тохиолдуулан үйлчлүүлэгч нартаа “Бага насны хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэндийн талаар зөвлөгөө” өгч 37 ширхэг гарын авлага тараасан.

- ЭМТөвийн хүүхдийн их эмч бусад эмч нартаа “Хүүхдийн өвчний цогц менежмент, яаралтай тусламж эрэмбэлэн ангилалт” сэвдээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 8 дугаар сарын 01-ны өдрийн 09 дүгээр албан даалгаврын дагуу сумын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зорилго бүхий 11 заалттай төлөвлөгөө батлуулаад ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд малчдын хаваржааг чөлөөлөх, отор нүүдэл хийлгэх ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулсан.

-Сумын хэмжээнд 2022-2023 онд урьдчилсан байдлаар 244491 толгой мал өвөлжүүлэх тооцоог гаргасан. Сумын аюулгүй нөөцийг бүрдүүлэх, малчдын хэрэгцээг хангахаар тус сумын “Богдын шар өндөр” гэдэг газар хадлангийн 10 салаа гарахаар бэлтгэл ажил хангагдсан.

- Хүнсний ногоо тариалж байгаа иргэдийн цахим санд оруулах ажил хийгдэж байна. Нийт 16 тариаланч иргэдийн мэдээллийг оруулаад байна.

-Ногооны талбайд төмс 2,5 га, хүнсний ногоо 0,75 га-д тариалалт хийсэн. Хүлэмжинд 10 иргэн нарийн ногоо тариалсан.

-Халзан суманд зохион байгуулагдаж буй “Улсын сайн малчдын зөвлөгөөн”-д 3 сайн малчин оролцож байна.

-Японы Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны Олон улсын судалгааны төвийн доктор, Эдийн засаг бизнесийн менежментийн сургуулийн танхимын эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй баг суманд дараах судалгааны ажлыг эхлүүллээ. Үүнд:

“БЭЛЧЭЭРИЙН ХАНДЛАГА” сэдвийн дор 3 чиглэлээр судалгаа хийв.

а/. Малчдын эдийн засаг

б/. Малчдын сэтгэлзүйн байдал

в/. Малчдын удам зүй (антропологи)

Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор угаалга туулга боловсруулалтын ажил эхлээд байна. Угаалгад: Ваннд угаасан Хонь-14681, ямаа-6108, шүршиж угаасан 250 үхэр, үхрийн гуурын боловсруултанд 200 үхэр, туулгалтад 2000 хонь ямаа хамрагдаад байна.

Үхрийн арьс товруутах өвчин Эрдэнэцагаан суманд гарсантай холбоотой идэвхгүй тандалтыг нийт 20 өрх хийгээд байна. Малын эмч нар малчин өрхөөр үзлэг тандалт хийх ажлыг цахим системд төлөвлөсөн. Малчин өрхийн үхэр сүрэгт арьс товруутахын үзлэг тандалтыг хийгээд ажлыг эхлүүлээд байна. Малчдад өвчний талаарх мэдээллийг цахим орчинд байршуулсан мөн малчидтай утсаар холбогдон мэдээлэл хүргэсэн.

Малаас хүнд халдварладаг Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээний нийт 58200 охин төлийг вакцинжуулалтад хамруулахаар төлөвлөөд байна. Вакцин тарих ажилд нийт 4 ажлын хэсэг гарна.

Гурав. Соёл, боловсролын чиглэлээр:

-Соёлын өвийн үндэсний төвийн даргын 2022.08.18 ны өдрийн А/35 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу түүх соёлын дурсгалт зүйлс булагдсан мэдээллийг шалгах, газрыг эрж хайх, илэрсэн тохиолдолд авран хамгаалах, малтлага хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар ирээд байна.

-“Нүүдэлчин-Монгол-2022” фестивальд сумын Соёлын төвөөс бие бүрэлдэхүүн оролцож, үндэсний өв соёлын үзэсгэлэн дэлгэсэн.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр:

8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 0-5 насны хүүхдийн сувилалын 2-р ээлжийг нээн ажиллуулж эхэлсэн. Үүнд баг тус бүрээс 2 буюу нийт 8 суурь эмгэгтэй хүүхдийг хамруулж эмчилгээ үйлчилгээнд:

- Шар сүүн бариа
- шар тосон бариа
- Төөнүүр
- Шарлага зэрэг уламжлалт эмчилгээг хийж байна.

8 сарын 2-ний өдрөөс Коронавируст халдварт өвчний тохиолдол батлагдан эмнэлэгт нийт 11 өвчтөн хэвтэн эмчлүүлж 1 өвчтөн АНЭ-т хүргэгдэж эмчлүүлсэн. Гэрийн тусгаарлалтанд нийт 25 иргэн гэртээ хянагдаж эмээр эмчлэгдсэн.

Хилийн цэргийн 7,8-р заставын нийт 37 цэрэг албан хаагчдийг коронавирусын халдварын эсрэг 2,4-р тунгийн дархлаажуулалтанд ажил дээр нь хүрч очин вакцинжуулсан.

Зургаа: Байгаль орчны чиглэлээр.

-Унгар улсын санхүүжилтээр хээрийн түймэр унтраах бүрэн тоног хэрэгслэлийг аймгийн Онцгой байдлын газраас тус суманд олгосон.

-ОНХС-ийн 40 сая төгрөгийн санхүүжилтээр хог зөөврийн шинэ машинтай болсон.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР

